



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 289

Улаанбаатар хот

Татан буугдсан хуулийн этгээдийн эд
хөрөнгийг балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Төрийн өмчит зарим хуулийн этгээдийг татан буулгах тухай” 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” төрийн өмчит хувьцаат компани татан буугдаж байгаатай холбогдуулан компанийн өр, авлагыг барагдуулах зорилгоор дуусгалтын тайланд тусгагдсан нийт 493,456,252.52 (дөрвөн зуун ерэн гурван сая дөрвөн зуун тавин зургаан мянга хоёр зуун тавин хоёр төгрөг тавин хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн болон эргэлтийн хөрөнгийг “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” төрийн өмчит хувьцаат компанийн эд хөрөнгийг шилжүүлсэнтэй холбогдуулан Татан буулгах комисс (В.Дарханбаатар)-т дараах ажлыг зохион байгуулахыг үүрэг болгосугай:

2.1. Дуусгалтын тайланд тусгагдсан үндсэн болон эргэлтийн хөрөнгийг “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн дотор хүлээлгэн өгөх;

2.2. Бусдад төлөх өр төлбөр болон бусдаас авах авлагыг шаардах эрхийг холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулан “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт шилжүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002060